



ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 01 сарын 28 өдөр

№ 04

Дархан уул аймаг

Сонирхлын зөрчилтэй, их хэмжээний хэлцэл хийх
зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 61.1.5 дахь заалт, 61.4. дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.3 дахь хэсэг, “Тээвэр Дархан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам”-ын 3.6 дахь заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 08 дугаар тогтоол, “Тээвэр дархан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит бус хурлын тэмдэглэл, Тооллогын комиссын 02, 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тээвэр Дархан” ХК-ийн хараат буюу толгой компани болох “Монгол Алт” ХК-ийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Хаан банк” ХК-иас 10,000,000,000.0 (арван тэрбум) төгрөгийн барилгын зээл авах, компанийн өөрийн эзэмшлийн, улсын бүртгэлийн Y-2003020673, Y-2003020671, Y-2003020679, Y-2003020674, Y-2003020680, Э-2003002006 дугаар бүхий үл хөдлөх хөрөнгүүд болон газруудыг зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэл хангуулах хэлбэрээр барьцаалуулах зөвшөөрөл олгож, холбогдох гэрээ хэлцэл байгуулах, барьцааны гэрээнд “Тээвэр Дархан” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (М.Оюун)-д олгосугай.

2. Дээрх сонирхлын зөрчилтэй буюу их хэмжээний хэлцэл нь хуулийн дагуу хийгдэж буй эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гарган танилцуулахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулахыг Аудитын хороо (Л.Амарсанаа), Ерөнхий нягтлан бодогч (Д.Бямбажаргал) нарт үүрэг болгосугай.



Ж.ОЧИРСҮХ